



Хаяг Баталгаажуулах А болон В Маягтууд Заавар, Хавсаргах Бичиг Баримтуудын Жагсаалт

Арлингтоны Улсын Сургууль (АУС) нь өөр айлд амьдарч буй өрхүүдийн Арлингтоны Хаягийг тодорхойлохын тулд жил бүр хаяг баталгаажуулах хоёр (2) тодорхойлолтыг дагалдах бичиг баримтуудын хамт ирүүлэхийг шаарддаг.

1. **Маягт А-** Эцэг эх/ Асран хамгаалагчийн Хаягийн Тодорхойлолт
2. **Маягт В-** Арлингтоны Оршин суугчийн Хаягийн Тодорхойлолт

Эдгээр тодорхойлолтуудыг тухайн гэр бүл нь Арлингтонд орон сууц эзэмшигч юм уу байр түрээслэгчтэй хамт амьдарч буйг баталгаажуулахад ашигладаг. Гэр бүл тус бүр жилд зөвхөн нэг удаа Маягт А болон В-г бөглөх шаардлагатай. Энэ шаардлага нь тухайн өрхөд буй бүх (сургуулийн насны) хүүхдэд адил хамаарна.

Шаардлагатай бичиг баримтуудын жагсаалт:

Арлингтоны оршин суугчтай хамт амьдарч буй эцэг эх/ асран хамгаалагч юм уу насанд хүрсэн сурагч нь дараах таван (5) бичиг баримтыг ирүүлэх шаардлагатай:

- ☐ Маягт А- Эцэг эх/ Асран хамгаалагчийн Хаягийн Тодорхойлолт
- ☐ Маягт В- Арлингтоны Оршин суугчийн Хаягийн Тодорхойлолт
- ☐ Байр эзэмших гэрчилгээ (*Deed*) юм уу Байрны Түрээсийн Гэрээ (*Lease*)
- ☐ Дараах жагсаалтаас нэмэлт хоёр (2) бичиг баримт бичиг

Нэмэлт бичиг баримтууд:

А & В маягтуудад мэдүүлсэнтэй адил эцэг эх/ асран хамгаалагчийн юм уу насанд хүрсэн сурагчийн нэр болон Арлингтоны хаяг бүхий хоёр (2) өөр бичиг баримтуудын эх хувийг дараах жагсаалтаас ирүүлнэ үү:

- ☐ Тухайн жилийн Холбооны, мужийн эсвэл хөрөнгийн татварын тайлан
- ☐ Сүүлийн цалинд хамаарах цалингийн тайлан
- ☐ Тээврийн Хэрэгслийн хүчинтэй бүртгэлийн гэрчилгээ
- ☐ Хамгийн сүүлд гарсан хэрэглээний төлбөрийн нэхэмжлэл
- ☐ Виржиниа мужийн жолооны үнэмлэх, эсвэл Засгийн Газраас олгосон зурагтай хүчинтэй биеийн байцаалт
- ☐ АНУ-н Холбооны, мужийн эсвэл орон нутгийн байгууллаас олгосон албан бичиг баримтууд
- ☐ Банкны сүүлд гарсан шинэ дансны хуулга
- ☐ Үл хөдлөхийн болон байр түрээслэгчийн хариуцлагын даатгалын гэрээ
- ☐ Сонгогчийн үнэмлэх
- ☐ Тухай жилийн татварын 1099 юм уу W-2 маягт

Нэмэлт бичиг баримтад буй хувь хүний Social Security Дугаар юм уу санхүүгийн нууцад хамаарах мэдээллийг дарж нууцална уу. АУС нь эдгээр бичиг баримтыг зөвхөн нэр, хаяг тодорхойлох зорилгоор ашигладаг болно.

Санамж: Бүх бичиг баримтууд хамгийн сүүлийн үеийн байх, тухайлбал хэрэглээний төлбөрийн нэхэмжлэл тухайн сард хамаарах ёстой.

Заавар:

Маягт А- Эцэг эх/ Асран хамгаалагчийн Хаягийн Тодорхойлолт:

1. Эцэг эх/ Асран хамгаалагч юм уу насанд хүрсэн сурагч энэ маягтыг бөглөж, гарын үсэг зурна.
2. Эрх бүхий нотариатаар маягтыг баталгаажуулна.

Маягт В- Арлингтоны Оршин суугчийн Хаягийн Тодорхойлолт:

1. Гэр бүлийн хамт амьдарч буй Арлингтоны оршин суугч энэ маягтыг бөглөж, гарын үсэг зурна.
2. Эрх бүхий нотариатаар маягтыг баталгаажуулна.

А болон В маягтууд хамаарах заавар:

- Жил бүр 7 сарын 1-с хичээлийн эхний өдрийн хооронд нотариатаар баталгаажуулж ирүүлэх шаардлагатай.
- Эцэг эх/ Асран хамгаалагчийн нэр хаяг бүхий нэмэлт хоёр бичиг баримтуудыг хавсаргаж ирүүлнэ.
- Эдгээрийг сургуулийн бүртгэл болон жил бүр өрхүүдийн хаяг баталгаажуулахад ашиглана.
- Зөвхөн тухайн хичээлийн жилийн түрш хүчинтэй байна.

Асуулт болон туслалцаа шаардлагатай бол:

- Өөрийн [Сургуулийн Бүртгэлийн Ажилтан](#)
- Арлингтоны Улсын Сургуулийн Welcome Center-н 703-228-8000 (Сонголт 1) утас, www.apsva.us/contact-aps/ хуудас.